



**МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2016 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 195

Улаанбаатар хот

Г Төрийн албаны зөвлөлийн
Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх салбар
зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг", Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны зөвлөлийн Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай. Үүнд:

Салбар зөвлөлийн дарга: - Төрийн нарийн бичгийн дарга,

Гишүүд:

- Төрийн захиргааны удирдлагын газрын дарга,
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга,
- Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга,
- Хуулийн хэлтсийн дарга,
- Зам, тээврийн хяналтын хэлтсийн дарга,

Салбар зөвлөлийн


нарийн бичгийн дарга: - Төрийн захиргааны удирдлагын газрын

Хүний неөцийн асуудал хариуцсан ахлах мэргжилтэн.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах, дарга, нарийн бичгийн дарга нарыг томилох тухай" Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын "Нэг"-ийн 8 дахь хэсэг, мөн тогтоолын 2 дугаар хавсралтын "Нэг"-ийн 6 дахь хэсэг, "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргыг томилж, тогтоолд өөрчлөлт оруулах тухай" мөн Зөвлөлийн 2015 оны 59 дүгээр тогтоол, "Төрийн албаны зөвлөлийн Зам, тээврийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, тогтоолд өөрчлөлт оруулах тухай" мөн Зөвлөлийн 2015 оны 161 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б.ЦОГОО



ТАЗ тогтоол 2016